

ЭРТ ИЛРҮҮЛЭГ НЬ ГОЛ ТҮЛХҮҮР МӨН

Та болон таны гэр бүл гепатитын в вирусийн илрүүлэг шинжилгээнд хамрагдах нь маш чухал. ГВВ нь Азийн улс оронд эрүүл мэндийн их том тулгамдсан асуудал юм.

» ШИНЖИЛГЭЭНД ХАМРАГДААРЙ

Эмчээсээ дараах цусны шинжилгээний талаар асуугаарай:

Гепатитын гадаргуугийн эсрэгтөрөгч (HBsAg):

ГВВ-ийн халдвартайг илэрхийлэх анхдагч үзүүлэгч, ГВВ-ийн цочмог ба архаг халдварын аль алинд нь цусанд илэрдэг.

ГВВ-ийн гадаргуугийн эсрэгбие (anti-HBs):

Цочмог гепатитын эдгэрэлтийн шатанд ийлдсэнд тодорхойлогдох ба энэ үед anti-HBs бас эерэг байна. Энэ үзүүлэлт нь ГВВ-ийн дархлаатай эсэхийг илтгэнэ.

Зөвхөн HBsAg цусны шинжилгээ архаг ГВВ-ийн халдвартайг илтгэнэ.



» ДАРХЛААЖУУЛАЛТАНД ХАМРАГДААРЙ

Хэрвээ таны HBsAg, anti-HBs цусны шинжилгээнүүд 2-уулаа сөрөг бол та ГВВ-ийн дархлаагүй, тиймээс ГВВ-ийн вакцин тариулаарай.

Та хүүхдээ ГВВ-ийн бүрэн тунт вакцинд зааврын дагуу хамруулаарай.

ГВВ-ийн вакцин нь ГВВ-ийн халдвараас, элэгний хорт хавдраас сэргийлдэг тул уг вакциныг ДЭМБ дэлхийн анхны хорт хавдрын эсрэг вакцин хэмээн нэрлэдэг.

ГВВ-ИЙН ЭСРЭГ ХАМТДАА



ГВВ-ийн эсрэг Jade Ribbon, JoinJade нэгдэгтүн, Дэлхий даяараа ГВВ, элэгний хорт хавдрын эсрэг дуу хоолойгоо нэгтгэн тэмцье.



Стэнфордын анагаахын их сургуулийн дэргэдэх Азийн элэгний төв

780 Welch Road, CJ 130
Palo Alto, CA 94304
Tel: 888.311.3331
Fax: 650.736.8001
liver.stanford.edu
#JOINJADE



Халдварт өвчин судлалын үндэсний төв

Баянзүрх дүүрэг, 14-р хороо,
Нам Ян Жүгийн гудамж
Утас: 976-11-458699
info@nccd.gov.mn
www.nccd.gov.mn

KNOW HBV



Гепатитын В вирус, элэгний хавдрын талаар мэдвэл зохих зүйлс



ГВВ-ИЙН ТАЛААРХ ЧИМЭЭГҮЙ БАЙДЛЫГ ТАСЛАН ЗОГСООЁ

- » ГВВ нь элэгний халдварт өвчин бөгөөд элэгний хатуурал, дутагдал, хорт хавдар зэрэг хүндрэлийн улмаас эрт нас барах гол шалтгаан болдог.
- » Ихэнх хүмүүс ГВВ-ийн халдвар авснаа мэддэггүй.
- » Архаг ГВВ-тэй 4-н хүн тутмын 1 нь элэгний хорт хавдар, дутагдлын улмаас нас бардаг, гэвч эрт оношилж удаан хугацааны туршид хянаж зөв эмчилгээг хийснээр уг хүндрэлээс сэргийлэх боломжтой.

ЭРҮҮЛ МЭТ ШИНЖ ТЭМДЭГҮЙ БАЙЛАА Ч АЛЬ ХЭДИЙН ГВВ-ИЙН ХАЛДВАР АВСАН БАЙХ МАГАДЛАЛТАЙ

ГВВ-ийн халдварын үед ямар ч шинж тэмдэг илэрдэггүй тул аюултай байдаг. Цусанд хийсэн элэгний үйл ажиллагааны шинжилгээ хэвийн гарч болдгийг анхаарах. Хэвлийгээр өвдөх, шарлах (шээсний өнгө харлах, арьс салст, нүд шарлах) зэрэг шинж тэмдэг илэрвэл ихэнхдээ эмчилгээний үр дүн нь оройтсон байдаг.

ГВВ-ИЙН ХАЛДВАР ДАМЖИХ ЗАМ НЬ ХДХВ-ТЭЙ АДИЛХАН ЗАМААР ДАМЖИН ХАЛДВАРЛАНА

1. Төрөх үед эхээс хүүхдэд халдвар дамжих

Азийн улс орнуудад ГВВ-ийн архаг халдвартай эхээс амаржих үед уг халдвар хүүхдэд дамжих нь түгээмэл.

2. Цусаар дамжин халдварлах

ГВВ-ийн халдвар нь халдвартай хүний цусаар дамжин халдварлана. Үүнд:

- » Шархнаас шарханд хүрэлцсэнээс.
- » Сахлын хутга, шүдний сойз зэргийг хүмүүстэй дундаа хэрэглэсэнээс.
- » Шивээсний зүү, чих цоолдог багаж, зүү тариур зэргийг дахин хэрэглэх.
- » Эмчилгээ оношилгоонд хэрэглэдэг эмнэлгийн хэрэгсэл, зүү тариурыг дахин ашиглах.

3. Бэлгийн замаар халдвар дамжих

ГВВ-ийн халдвартай хүнтэй хамгаалалтгүй бэлгийн хавьталд орсноор ГВВ халдварлана.

ГВВ НЬ УС БОЛОН ХООЛ ХҮНСЭЭР ДАМЖИН ХАЛДВАРЛАДАГГҮЙ

ГВВ нь дор дурдсан замаар дамжин халдварлахгүй гэдгийг ойлгох нь маш чухал. Үүнд:

- » Хоол хүнс хуваалцсанаар.
- » Аяга таваг, хоолны хэрэгсэл дундаа хэрэглэсэнээр.
- » Нулимс, хөлс, шээс, өтгөн ялгадсаар, ханиах, найтаах, тэврэх, үнсэх, хөхний сүүгээр, шумуулаар, гар барих.

ГВВ-ийн халдвартай хүмүүсээс зай барьж хөндийрөх ямар ч шаардлага байхгүй, ийм хүмүүсийг ажил, сургууль, өдөр тутмын идэвхтэй үйл ажиллагаанаас нь тусгаарлах ёсгүй.

ХЭРВЭЭ ТА ГВВ-ИЙН ХАЛДВАРТАЙ БОЛ ЮУГ АНХААРАХ ЁСТОЙ ВЭ?

» ЭРТ ИЛРҮҮЛЭГТ ХАМРАГДАХ

Ямар нэгэн зовуур илрээгүй ч ГВВ-ийн шинжилгээнд хамрагдах нь чухал. Эмчээсээ дараах шинжилгээний талаар лавлаарай.

Шинжилгээ	Хяналт	Шинжилгээний давтамж
АЛАТ	Элэгний гэмтэл	6-н сар тутам
АФП	Элэгний хавдар	6-н сар тутам
ГВВ ДНХ	Вирусий идэвхжил	1 жил тутам
Эхо	Элэгний хавдар	6-н сар тутам

*Хэрвээ та хатууралтай, гэр бүлд нь элэгний хорт хавдартай хүн байсан бол нас харгалзахгүй 6 сар тутам эхо хийлгэх.

Хэрэв элэгний хорт хавдрыг эрт үед нь оношилвол амжилттай эмчлэгдэх боломжтой.

» ГВВ-ийн халдвар эерэг илэрсэн хүн бүр вирусийн эсрэг эм уух шаардлагагүй

Хэрвээ таны АЛАТ-ын түвшин нэмэгдсэн бол элэгний гэмтлийг илтгэх учир эмчээсээ вирусийн эсрэг эмийн талаар лавлаарай.

Хэрэв та хорт хавдрын химийн эмчилгээтэй байгаа бол ГВВ-ийн эмчилгээнд хамрагдах, болзошгүй сэдрэл үүсэхээс хамгаалах, элэгний дутагдлаас сэргийлэх талаар эмчээсээ лавлаарай.

» Гепатитын А вирусийн вакцинд хамрагдах » Архи согтууруулах зүйлсээс татгалзах » Өөрийн хайртай хүмүүсээ халдвараас хамгаалах

Таны гэр бүл ГВВ-ийн эсрэг дархлаатай эсэхийг шалгаж дархлаагүй бол вакцинд хамруулаарай.

Та жирэмсэн бол хүүхдээ төрсөн дариуд нь 12 цагийн хугацаанд ГВВ-ийн эсрэг вакцин, HBIG 2-ыг тариулан вакцины бүрэн тунг товллын дагуу хийлгээрэй. ГВВ-ийн вакцин нь таны хүүхдийг халдвараас 95% хамгаална.